



Ойн менежмент төлөвлөгөөнд суурилсан бизнес төлөвлөгөө боловсруулах , загвар бизнес хөгжүүлэх

“Үйзэн хайрхан” нөхөрлөлийн жишээн дээр

Бизнес төлөвлөгөө

- Бизнес төлөвлөгөө гэдэг нь:
- бизнес хамт олны стратеги, зорилтыг тодорхойлдог ба түүний үйл ажиллагаагаа эрхлэх бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа, тэргүүлэгчдийн ур чадвар, санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлт, үр ашгийг жил тутам сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой цаг хугацаагаар төлөвлөн боловсруулсан баримт юм.

Бизнес төлөвлөгөө боловсруулах үндсэн 4 шалтгаан

- ◆ Болзошгүй асуудлыг урьдчилан харж илрүүлэх
- ◆ Хөрөнгө оруулагчдыг татах
- ◆ Тухайн байгууллагатай танилцах
- ◆ Удирдлага болон хяналтын хэрэгсэл

Бизнес төлөвлөгөөний үүрэг

- ◆ Бизнесийн стратегийг боловсруулахад ашиглах
- ◆ Төлөвлөлт
- ◆ Хөрөнгө оруулалт татах
- ◆ Байгууллагын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд үйлдвэрлэлд хувь хөрөнгөө эсвэл өөрийн технологио нийлүүлэн хамтран ажиллахыг сонирхож буй этгээдүүдийг татах

Бизнес төлөвлөгөөнд тавигдах шаардлага

- Тодорхой байх
- Энгийн бөгөөд ойлгомжтой бичнэ
- Нэг өгүүлбэрт хэт олон санаа илэрхийлэх шаардлагагүй
- Өөрийн санаа бодлоо цэгцтэй гаргаж өгнө
- Тохиромжгүй ишлэл хэрэглэхгүй байх
- Шаардлагатай хэсэгт график, хүснэгт диаграм оруулж өгөх
- Товч байх
- Бүлэг хэсэг нь уялдаа холбоотой байх
- Үнэн зөв
- Тоо баримтаар баталгаажсан байх

Ойн нөхөрлөлийн бизнес ТӨЛӨВЛӨГӨӨ

- Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хуульд зааснаар нутгийн ард иргэд нөхөрлөл байгуулан байгалийн тодорхой төрлийн баялагийг хамгаалах, гэрээгээр эзэмшиж ашиглах эрх нь нээлттэй болсон билээ. Энэ заалтын дагуу одоогийн байдлаар улсын хэмжээнд 8,8 мянган гишүүд бүхий 4,3 мянган өрхийг хамарсан 260 гаруй нөхөрлөл 440,0 мянган га талбайг хариуцан үйл ажиллагаа явуулж байна
- Ойн нөхөрлөлүүд ойгоо хамгаалах, хамгаалсныхаа хэрээр үр шимийг нь тогтвортой хүртэхийн тулд байгалийн нөөц, түүний дотор ойн баялаг, мал аж ахуйд түшиглэсэн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх замаар зах зээлийн харилцаанд орж өөрсдийн санхүүгийн чадавхиа дээшлүүлэх боломжтой.
- Гагцүү нарийн тооцсон бизнес төлөвлөгөө боловсрууж, хэрэгжүүлснээр энэхүү боломжийг хэрэгжүүлж чадна.

Бизнес төлөвлөгөөний хувилбар загварууд

Санхүүгийн зохицуулах хорооны зөвлөмж	ТХГН-ийн бизнес төлөвлөгөө	Нөхөрлөлийн загвар	Загвар төлөвлөгөө
<p>I. Гүйцэтгэлийн хураангуй</p> <p>II. Бизнесийн танилцуулга</p> <p>1.Компанийн түүх</p> <p>1.1. Компанийн түүх</p> <p>1.2. Одоогийн явуулж буй үйл ажиллагаа</p> <p>1.3.Хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшилт</p> <p>1.4.Бүтэц зохион байгуулалт, удирдлага, хүний нөөц:</p> <p>3.Зах зээлийн нөхцөл төлөв байдал</p> <p>2.1.Зах зээл, хэрэглэгч, зах зээлийн ерөнхий чиг хандлага:</p> <p>2.2.Бизнесийн хууль эрх зүйн орчин:</p> <p>2.3.Өрсөлдөөн, өрсөлдөгчид</p> <p>2.4.Бизнес төлөвлөгөө бичих болсон үндэслэлүүд</p> <p>3.Төлөвлөсөн бизнесийн үйл ажиллагаа:</p> <p>3.1.Бүтээгдэхүүн үйл ажиллагааны төлөвлөгөө:</p> <p>3.2.Маркетингийн төлөвлөгөө</p> <p>3.3.Менежментийн төлөвлөгөө:</p> <p>3.4.Санхүүгийн төлөвлөгөө:</p> <p>3.5.Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө:</p> <p>3.6.Эрсдэлийн менежмент /бууруулах</p>	<p>1. Ерөнхий шаардлагууд</p> <p>2. Бүтэц, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа</p> <p>3. Бизнесийн орчны нөхцөл байдлын дүн шинжилгээ SWOT шинжилгээ</p> <p>4.Маркетингийн төлөвлөгөө</p> <p>4.1. Үнэ бүрдүүлэлт, үнийн бодлого</p> <p>4.2. Идэвхжүүлэлтийн төлөвлөгөө</p> <p>5. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө</p> <p>6. Санхүүгийн төлөвлөлт</p> <p>6.1. Орлогын төсөвлөлт</p> <p>6.2. зардлын төсөвлөлт</p> <p>Санхүүжилтийн цоорхойг нөхөх боломжит эх үүсвэрүүд</p> <p>7.Эрсдэлийн төлөвлөгөө</p>	<p>1. Төлөвлөгөөний хураангуй</p> <p>2. Ерөнхий хэсэг Танилцуулга</p> <p>- Хэтийн зорилго</p> <p>- Төсөөлөл</p> <p>1. Эзэмших нутаг дэвсгэрийн өнөөгийн төлөв</p> <p>2. Зах зээл бүтээгдэхүүний судалгаа</p> <p>- Зах зээлийн шинжилгээ</p> <p>- Бүтээгдэхүүн борлуулалтын стратеги</p> <p>1. Зорилго зорилтууд</p> <p>2. Байгалийн нөөцийг хамгаалах төлөвлөгөө</p> <p>3. Нөхөрлөлийн бүтэц зохион байгуулалт</p> <p>4. Санхүүгийн төлөвлөгөө</p> <p>5. Эрсдэлийн үнэлгээ</p> <p>6. Хавсралт материал</p>	<p>1. Ерөнхий хэсэг</p> <p>- Ерөнхий шаардлага</p> <p>- Төлөвлөгөөний хураангуй</p> <p>2. Танилцуулга</p> <p>Бүтэц, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа</p> <p>3. Бизнесийн орчны нөхцөл байдлын дүн шинжилгээ</p> <p>- SWOT шинжилгээ</p> <p>- Зах зээлийн шинжилгээ</p> <p>- Бүтээгдэхүүн борлуулалтын стратеги</p> <p>- Зорилго зорилтууд</p> <p>4. Маркетингийн төлөвлөгөө</p> <p>- Үнэ бүрдүүлэлт, үнийн бодлого</p> <p>- Идэвхжүүлэлтийн төлөвлөгөө</p> <p>5. Санхүүгийн төлөвлөлт</p> <p>- Орлогын төсөвлөлт</p> <p>- Зардлын төсөвлөлт</p> <p>6. Эрсдэлийн үнэлгээ төлөвлөгөө</p> <p>7. Хяналт шинжилгээ</p>

Ойн нөхөрлөлийн бизнес төлөвлөгөөний зэрэглэл

- Ойн нөхөрлөлүүд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээнээс хамааран бизнес төлөвлөгөөг анхан шат, дунд шат, өндөр түвшний гэсэн гурван түвшинд боловсруулан хэрэгжүүлнэ.
- Анхан шатны бизнес төлөвлөгөө нь тодорхой нэг хугацаанд зөвхөн нэг төрлийн бүтээгдэхүүн бага хэмжээгээр үйлдвэрлэн борлуулах нөхөрлөлд тохиромжтой.
- Дунд шатны бизнес төлөвлөгөөг хоёр ба түүнээс олон төрлийн бүтээгдэхүүнийг их хэмжээгээр хэд хэдэн хэрэглэгчдэд удаан хугацаанд нийлүүлэхээр сонгосон нөхөрлөлүүд ашиглана. Эдгээр нөхөрлөл бизнес төлөвлөгөөг бүрэн эхээр нь боловсруулж, дээр нь өрсөлдөгч болон зах зээлийн судалгаа хийж, удирдлага зохион байгуулалт болон эрсдэлийг тодорхойлж, мөн бизнес эхлүүлэхэд шаардлагатай эхлэлийн хөрөнгө зэргийг тооцсоноор боломжит худалдан авагчийг олоход хангалттай мэдээлэлтэй болно.
- Өндөр түвшний бизнес төлөвлөгөөг ижил нөхцөлтэй боловч тендэрт оролцох эсвэл банк, санхүүгийн байгууллагаас зээл авах сонирхолтой нөхөрлөлүүд ашиглана.

Ойн нөхөрлөлийн бизнес төлөвлөгөөний зэрэглэл, бүтэц



Архангай аймгийн Цэнхэр сумын “Үйзэн хайрхан” нөхөрлөлийн загвар бизнес төлөвлөгөө

Энхүү загвар төлөвлөгөөг ойн нөхөрлөлийн дунд шатны бизнес төлөвлөгөөний түвшинд удиртгал болон 7 хэсгийн бүрэлдэхүүнтэй төлөвлөв

- Удиртгал хэсэгт бизнес төлөвлөгөөний ач холбогдол түүнд тавигдах шаардлагууд, тус бизнес төлөвлөгөөний товч агуулгыг танилцууллаа.
- Нэгдүгээр хэсэгт тусгай нөхөрлөлийн танилцуулга үйл ажиллагааны чиглэлүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх бизнес бүлгүүдийг тодорхойлов.
- Хоёрдугаар хэсэгт нөхөрлөлийн одоогийн байдалд хийсэн SWOT дүн шинжилгээг үзүүлэв.
- Гуравдугаар хэсэгт нөхөрлөлийн үйл ажиллагааны зорилго, маркетингийн төлөвлөгөө, идэвхжүүлэлтийн арга хэмжээнүүдийг оруулав.
- Дөрөвдүгээр хэсэгт санхүүгийн төлөвлөлт тусгагдлаа. Энд орлогын эх үүсвэр, зардлын төсөвлөлт, үр ашгийн тооцоо, хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хугацаа зэрэг үзүүлэлтүүдээр бизнес бүлэг тус бүрээр тооцов. Мөн шинээр эрхлэх төслийн тооцоог хийж авч үзэв.
- Тавдугаар хэсэгт өрсөлдөгчдийн судалгааг бизнес бүлэг тус бүрээр гаргав.
- Зургадугаар хэсэгт эрсдлийн төлөвлөгөө гаргав. Нөхөрлөл нь байгаль, цаг уурын бэрхшээл, мөн зах зээлийн нөхцөл, үйлчлүүлэгчдийн тоо, сонирхол буурах, санхүүгийн хүчин зүйлс зэрэг гэнэтийн ямар нэгэн хүндрэл, дэд бүтцийн болон эрхзүйн орчинд гарсан өөрчлөлт зэргээс шалтгаалан бизнесийн зорилгыг хэрэгжүүлэх үйл явц удаашрах болон зарим үйл ажиллагаанууд биелэгдэхгүй байж болно. Тохиолдох эрсдэлүүдийг урьдчилан тооцохдоо илрэх хэлбэр, учирч болох үр дүн, тухайн эрсдэлээс хамгаалах, зайлсхийх, тараан байршуулах арга хэмжээнүүдийг төлөвлөв.
- Долдугаар хэсэгт хяналт үнэлгээ хийх зарчим арга замыг заав.

1. Танилцуулга

Ойн нөхөрлөлийн нэр, Үйзэн хайрхан

Нөхөрлөлийн хаяг, байршил: Архангай аймаг, Цэнхэр сумын Алтан овоо баг

Нөхөрлөл байгуулагдсан он.сар.өдөр: 2009 оны 9 сарын 25-нд

Өрх, гишүүдийн тоо: 11/18

Нөхөрлөлийн гишүүдийн боловсрол, мэргэшил: Бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой, малчин, жолооч, тракторчин, нөхөрлөлийн ойн мэргэжилтэн О. Аръяабал Архангай аймгийн МТҮС-ийг ой үржүүлэг мэргэжлээр төгссөн.

Түншлэгч байгууллага: Цэнхэр сумын “Тэлээ таван хайрхан” ХХК

Эзэмшил ойн талбайн хэмжээ: 4691 га

Үйл ажиллагааны чиглэл: Ойг хамгаалах, ойг арчлах, ойжуулалт, мод үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх, байгалийн дагалт баялаг ашиглах. Эдгээр үйл ажиллагааг дөрвөн үндсэн чиглэл болгож бизнес бүлгүүд хариуцуулан хэрэгжүүлнэ. Бизнес бүлгүүдийг дараахи байдлаар зохион байгуулан ажиллуулна.

Бизнес төлөвлөлт

Маркетингийн төлөвлөгөөг бизнес бүлэг тус бүрээр хийсэн бөгөөд эрсдлийн төлөвлөгөөг бизнес бүлгүүд ашиг алдагдлаа харилцан нөхөх байдлаар төлөвлөв.

Бизнес бүлгүүд тэдгээрийн үйл ажиллагаа

Бизнес бүлгүүд	Шаардагдах мэдлэг чадварын түвшин	Ажил үүргийн чиглэл
1 Ойн аж ахуйн арга хэмжээ	Ойн аж ахуйн арга хэмжээний анхан шатны мэдлэг эзэмшиж, үйл ажиллагаа явуулах чадвартай болсон байх	Ойн мэргэжлийн байгууллага болох “Тэлээ таван хайрхан” ХХК-ий үйл ажиллагаан туслан гүйцэтгэгчээр оролцоно
2 Байгалийн дагалт баялаг ашиглах	Самар жимс мөөг эмийн ургамлыг ашиглах эрхзүйн үндэс, бэлтгэх уламжлалт болон шинжлэх ухааны арга технологийн мэдлэг эзэмшсэн байх	Менежментийн төлөвлөгөө болон ой зохион байгуулалтын материалд тусгагдсан талбайд арчилгаа, хамгаалалт, ашиглалтын үйл ажиллагааг явуулна
3 Мод сөөгний үр бэлтгэх, тарьц суулгац үржүүлж борлуулах	Бэлтгэх үр, үржүүлэх мод сөөгний биологи экологийн онцлог үржүүлэх агротехникийн мэдлэг эзэмшсэн байх	- Үр бэлтгэх талбайд арчилгаа хамгаалалтын ажлыг явуулж стандартын шаардлага хангасан үр бэлтгэх - Хүлэмж мод үржүүлгийн талбайд шинэс хайлаасны тарьц үржүүлэх
4 Нийтлэг үйл ажиллагаа	Мал аж ахуй эрхлэх уламжлалт мэдлэг	-Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх - Аялагч жуулчдад унаа морь хөлслүүлэх

2. Нөхөрлөлийн бизнесийн орчны нөхцөл байдлын дүн шинжилгээ

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
<ul style="list-style-type: none">• Байгалийн нөөц ихтэй• Байршлын хувьд УБ хот болон аймгийн төвтэй харьцангуй ойр, дэд бүтэц сайтай• Ой зохион байгуулалтын ажлыг өндөр нарийвчлалтай гүйцэтгэж, загвар талбай, үрийн талбайг тусгаарлаж, хэрэгжүүлэх арга хэмжээг менеж-ментийн төлөвлөгөөнд нарийвчлан тусгасан	<ul style="list-style-type: none">• Нөхөрлөлийн дийлэнх гишүүд өдөр тутам мал аж ахуйн ажил эрхэлж ойн аж ахуйн арга хэмжээнд байнга оролцох боломж багатай• Маркетинг болон идэвхжүүлэлтийн бодлого тааруу
БОЛОМЖ	АЮУЛ
<ul style="list-style-type: none">• Байгалийн дагалт баялаг ашиглах талбайг тусгаарлаж арчлалт хамгаалалтын ажлыг хийснээр нэгж талбайгаас ашиглах гарцыг нэмэгдүүлэх• Зөгий үржүүлж орлогын шинэ эх үүсвэр бий болгох боломжтой	<ul style="list-style-type: none">• Малын тооны өсөлтөөс шалтгаалан бэлчээрийн даац хэтрэх• Уур амьсгалын өөрчлөлт ган зудын аюул нүүрлэх• Ойн түймэр хөнөөлт шавьж, өвчин дэлгэрэх

3. Маркетингийн төлөвлөлт

Нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь дараах чиглэлүүдээр тодорхойлогдно. Үүнд:

- Ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх
- Байгалий
- н дагалт баялаг ашиглах
- Мод сөөгний үр бэлтгэх, тарьц суулгац үржүүлж, борлуулах
- Сүү, цагаан идээ бэлтгэж борлуулах
- Аялагч жуулчлагч нарт морь хөлслүүлэх
- Зөгий үржүүлэх

Маркетингийн төлөвлөлтийг бизнесийн бүлэг тус бүрээр хийж холбогдох арга хэмжээнүүдийг төлөвлөлөө.

Бизнесийн 1-р бүлгийн маркетинг төлөвлөгөө

Бүтээгдэхүүний нэр	Түлээний мод
Борлуулах үнэ	60000
Зорилтот хэрэглэгч	Сум, аймгийн иргэд албан байгууллагууд
Борлуулах газар	Иргэд, гэрээт албан байгууллагууд
Бүтээгдэхүүний чанар	<ol style="list-style-type: none">2-2,4 метрээр тайрсан түлшний өмхгүй хуурай мод30 см урттай хагалж шуудайлсан түлшний мод
Бүтээгдэхүүнээ сурталчлах хэлбэр	<ul style="list-style-type: none">Албан байгууллагуудтай гэрээ байгуулж нийлүүлэхНөхөрлөлийн хариуцан хамгаалж буй ойгоос ойн цэвэрлэгээний журмаар ойн хууль тогтоомжийн дагуу бэлтгэсэн чанарын шаардлага хангасан түлш гэдгийг сурталчлан хэрэглэгчдэд танигдахТухайн жилийн 9-р сараас өмнө захиалга өгсөн өрхүүдэд тодорхой хэмжээний хөнгөлөлт үзүүлэх
Шаардлагатай зөвшөөрөл	Ойн санг хариуцан хамгаалах тухай гэрээ зөвшөөрөл, батлагдсан менежментийн төлөвлөгөө, хатсан болон унанги мод бэлтгэж цэвэрлэх зөвшөөрөл, гоожин төлөх
Борлуулах түнш	Хамгаалалтын захиргаа, сумын Засаг даргын дэмжлэг авах

Бизнесийн 2-р бүлгийн маркетинг төлөвлөгөө

Бүтээгдэхүүний нэр	Самар	Аньс жимс	Мөөг
Борлуулах үнэ	3000	5000	6000
Зорилтот хэрэглэгч	Аймгийн төв, нийслэлийн иргэд		
Борлуулах газар	Иргэд, гэрээт албан байгууллагууд		
Бүтээгдэхүүний чанар	Стандартын болон эрүүл ахуйн шаардлага хангасан байна		
Бүтээгдэхүүнээ сурталчлах хэлбэр	<ul style="list-style-type: none">Хангайн нурууны БЦГ-ын орчны бүсээс бэлтгэсэн экологийн цэвэр бүтээгдэхүүн гэдгийг хэрэглэгчдэд танилцуулахЦахим сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах		
Шаардлагатай зөвшөөрөл	Ойн санг хариуцан хамгаалах тухай гэрээ зөвшөөрөл, байгалийн дагалт баялаг ашиглах зөвшөөрөл		
Борлуулах түнш	Хамгаалалтын захиргаа, сумын Засаг даргын дэмжлэг авах		

Бизнесийн 3-р бүлгийн маркетинг төлөвлөгөө

Бүтээгдэхүүний нэр	Шинэсний үр	Шинэс модны тарьц
Борлуулах үнэ	120000	100
Зорилтот хэрэглэгч	Тусгай зөвшөөрөл бүхий ойн мэргэжлийн байгууллагууд, мод тарих сонирхол бүхий иргэд,	
Борлуулах газар	Иргэд, гэрээт албан байгууллагууд	
Бүтээгдэхүүний чанар	Стандартын шаардлага хангасан, I, II зэргийн үр тарьц	
Бүтээгдэхүүнээ сурталчлах хэлбэр	<ul style="list-style-type: none">• Гарал үүсэл чанарын үзүүлэлтийг тодорхой танилцуулна• Цахим сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах	
Шаардлагатай зөвшөөрөл	Ойн санг хариуцан хамгаалах тухай гэрээ зөвшөөрөл	
Борлуулах түнш	Ойн судалгаа хөгжлийн төв, Орон нутгийн байгаль орчин, аялал жуулчлалын газрууд. ТХГН-ийн хамгаалалтын захиргаад	

Нийтлэг хэрэгжүүлдэг уламжлалт чиглэл болох 4-р бүлгийн үйл ажиллагаанд маркетингийн төлөвлөлт хийх шаардлагагүй гэж үзсэн бөгөөд шинээр эрхлэх Зөгий үржүүлгийн ажилд энэ удаа төлөвлөлт хийсэнгүй.

ИДЭВХЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөхөрлөлийн үйл ажиллагааны идэвхжүүлэлтэд ашиглах арга хэрэгсэл

Зорилт 1. Нөхөрлөлийн гишүүдийн мэргэжлийн ур чадвар, менежментийн арга барилыг өөрчлөн сайжруулж, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх

Зорилт 2. Байгалийн дагалт баялаг ашиглах талбайг тусгаарлаж арчлалт хамгаалалтын ажлыг хийснээр нэгж талбайгаас ашиглах гарцыг нэмэгдүүлэх.

Зорилт 3. “Тэлээ таван хайрхан” ХХК-тай хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж ойн аж ахуйн арга хэмжээг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх

Зорилт 4. Нөхөрлөлийн гишүүдийг аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцуулах замаар орлого олох эх үүсвэр бий болох нөхцөлийг бүрдүүлэх

Зорилт 5. ТХГН–ийн хамгаалалтын захиргаа, орон нутгийн веб хуудас, хэвлэл мэдээлэлийн хэрэгслээр нөхөрлөлийн үйл ажиллагаа бүтээгдэхүүнийг өргөн сурталчилж олон нийтэд хүргэх.Энэхүү аргыг ашигласнаар мэдээлэл, сурталчилгааг хамгийн бага зардлаар олон хүнд хүргэх боломжтой болох юм.

4. Санхүүгийн төлөвлөлт



Бизнесийн 1-р бүлгийн санхүүгийн төлөвлөгөө

Бизнесийн 1-р бүлэг нь “Тэлээ таван хайрхан” ХХК-ийн туслан гүйцэтгэгчээр арчилгааны огтлолтыг хэрэгжүүлэх бөгөөд ажилласан хүмүүс цалин авна. Харин ойн цэвэрлэгээний ажлыг бие даан хэрэгжүүлэх бөгөөд түлээний мод бэлтгэж борлуулах замаар орлого бүрдүүлнэ.

Борлуулалтын орлого

Бүрээгдэхүүн	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ	Тоо хэмжээ	Бүгд
Ойн цэвэрлэгээнээс				
Шуудайлсан түлээ	Шуудай	4000	300	1200000
Түлээний мод	м ³	200	60000	12000000
Арчилгааны огтлолтоос				
Цалин	Хүн өдөр	20000	50	1000000
Дүн				14,200,000

Бизнесийн 1-р бүлгийн санхүүгийн төлөвлөгөө

Гол зардлууд

Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд
Моторт хөрөө худалдаж авах	ш	2	150000	300000
Сүх	ш	4	20000	80000
Шуудай	ш	400	170	68000
Ачааны машин түрээслэх	Өдөр	6	100000	600000
Ажилчдын цалин	Өдөр	20	20000	400000
Хөрөөчний цалин	Өдөр	20	15000	300000
Санхүүчийн цалин	Өдөр	1	20000	20000
Борлуулагчийн цалин	Өдөр	26	20000	520000
Шатахуун	л	20	2500	50000
Тос	л	5	4000	20000
Дүн				2358000

Бизнесийн 1-р бүлгийн санхүүгийн төлөвлөгөө

Тоног төхөөрөмжийн элэгдэл хорогдлын зардал

Тоног төхөөрөмж	Нэгжийн үнэ	Тоо хэмжээ	Нийт үнэ	Ашиглах хугацаа	Жилийн элэгдэл
Хөрөө	150000	2	300000	5	60000
Сүх	20000	4	80000	10	8000
					68000

Бусад зардал

Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд
Түлээний гоожин	м ³	100	1400	140000
Хөрөөний гинж	ш	2	10000	20000
Хөрөөний сэлбэг				30000
Дүн				190000

Бизнесийн 1-р бүлгийн санхүүгийн төлөвлөгөө

Үр ашгийн тооцоо

Ашиг тооцох		Дүн
Нийт орлого		14,200,000
Зардал	Гол зардлууд	2358000
	Тоног төхөөрөмжийн элэгдэл хорогдлын шимтгэл	68000
	Бусад зардал	190000
	Зардлын дүн	2,616,000
Татварын өмнөх ашиг		11,584,000
Орлогын албан татвар /10%/		11,584,00
Татварын дараахи цэвэр ашиг		10,425,600

Бизнесийн 1-р бүлгийн санхүүгийн төлөвлөгөө

Хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хугацаа

Үзүүлэлтүүд	Дүн
Татвар төлсний дараахи цэвэр ашиг	10,425,600
Хөрөнгө оруулалтын (Зардлын дүн)	2,616,000
Хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хувь	250%

Бизнес төлөвлөгөөний зардал тооцох нэг гол алхам бол хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хувийг тооцох явдал юм. Энэхүү тооцоогоор үйлдвэрлэлд оруулсан хөрөнгөө хэдий хугацааны дараа нөхөх вэ гэдгийг гаргаж ирнэ. Тэгэхдээ бизнес бүлгүүд өөрсдөө бие даан төлөх боломжийг тооцон ажиллах нь бусад бүлэгтээ дарамт болохгүй сайн талтай юм. Бизнесийн 1-р бүлгийн тооцоогоор энэхүү үзүүлэлт 250% гарч байгаа нь хөрөнгө оруулалтаа нэг жилийн дотор бүрэн төлөөд 150 хувийн ашигтай ажиллах боломжтой гэсэн үг. Энэхүү орлогынхоо тодорхой хувийг дундын сандаа нийлүүлж нэмж тоног төхөөрөмж авах нөхцөл бүрдэж байна.

Бизнесийн 2-р бүлгийн санхүүгийн төлөвлөгөө

Борлуулалтын орлого

Бүрээгдэхүүн	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ	Тоо хэмжээ	Бүгд
Самар	кг	3000	1500	4500000
Аньс жимс	кг	5000	500	2500000
Мөөг	кг	6000	250	1500000
Дүн				1500000

Гол зардлууд

Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд
Жимс түүх сам авах	ш	5	25000	125000
Жимс мөөг хадгалах тээвэрлэх сав	ш	10	20000	200000
Цалин хөлс	Хүн/өдөр	10	20000	200000
Дүн				525000

Бизнесийн 2-р бүлгийн санхүүгийн төлөвлөгөө

Үр ашгийн тооцоо

Ашиг тооцох	Дүн
Нийт орлого	1500000
Гол зардлууд	525000
Татварын өмнөх ашиг	975,000
Орлогын албан татвар /10%/	97500
Дүн	877,500

Хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хугацаа

Үзүүлэлтүүд	Дүн
Татвар төлсний дараахи цэвэр ашиг	877,500
Хөрөнгө оруулалтын (Зардлын дүн)	525000
Хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хувь	167%

Хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хувийг бизнесийн 2-р бүлэгт тооцож үзэхэд 167% байгаа нь бүлэг зардлаа бүрэн төлөөд 67%-ийн ашигтай ажиллах боломжтой байна.

Бизнесийн 3-р бүлгийн санхүүгийн төлөвлөгөө

Борлуулалтын орлого

Бүрээгдэхүүн	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ	Тоо хэмжээ	Бүгд
Шинэсний үр	кг	80000-120000	20-150	18000000
Шинэсний тарьц	ш	100	20000	2000000
Дүн				20000000

Бизнесийн 3-р бүлгийн санхүүгийн төлөвлөгөө

Ажлын хөлсний тооцоо

№	Хийх ажил	Үнэлэх нэгж	Хэмжээ	Нэгжийн үнэлгээ	БҮГД ҮНЭ
1	Хүлэмж барих	Хүн/цаг	30	5000	150000
2	Хашаа барих	Хүн цаг	500	5000	2500000
3	Хүлэмжний хөрс бэлтгэх хар шороо элс ачиж буулгах, микоризтой хөрс бэлтгэх	Хүн/цаг	200	5000	1000000
4	Банзан хашлага хийж, хөрс шороог шигшиж хольж хүлэмжний хөрсийг дэвсэж бэлтгэх	Хүн/цаг	250	5000	1250000
5	Хүлэмжний хөрсийг усалж ариутгах	Хүн/цаг	20	5000	350000
6	Үрийг дэвтээж ариутгаж цаслаж бэлтгэх	Хүн/цаг	30	5000	
7	Үр тарих	Хүн/цаг	20	5000	
	Усалгаа арчилгаа	Сар	6	600000	3600000
	Дүн				8850000

Бизнесийн 3-р бүлгийн санхүүгийн төлөвлөгөө

Материалын үнийн тооцоо

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Хашааны шон	ш	400	2000	800000
2	Хадаас	кг	11	3000	33000
3	5-10 тн багтаамжтэй усны сав	ш	1	1000000	1000000
4	Шинэсний үр	кг	7 кг	120000	840000
5	Маргенц хүчлийн кали	гр	300	300	90000
6	Формалин 40%	мл	500	500	250000
7	20x5x400 банз	ш	20	15000	300000
8	Усалгааны гар шүршүүр	ш	2	10000	20000
9	Ажлын бээлий	ш	20	2200	44000
10	Психометртай термометр	ш	6	9500	12000
11	Хөрс сийрүүлэх гар багаж	ш	5	3000	15000
12	Хүлэрт хөрс	л	100	918	91800
13	Шим бордоо	кг	100	845	845000
14	Шороо зөөх түрдэг тэрэг	ш	2	120000	240000
15	Мананжуулах төхөөрөмж	ком	1		500000
16	Эрдэс бордоо	кг	10	4000	40000
17	Гэрээгээр авах 9 зүйл				10437000
	Дүн				15557800

Бизнесийн 3-р бүлгийн санхүүгийн төлөвлөгөө

Үр ашгийн тооцоо

Ашиг тооцох		Дүн	
Нийт орлого		20000000	
Зар-дал	Ажлын хөлс	8850000	Төслийн зардлаар
	Материалын зардал	15557800	
Татварын өмнөх ашиг		20000000	
Орлогын албан татвар /10%/		200000	
Татварын дараахи цэвэр ашиг		19,800,000	

Хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хугацаа

Үзүүлэлтүүд	Дүн
Татвар төлсний дараахи цэвэр ашиг	20000000
Хөрөнгө оруулалтын (Зардлын дүн)	24,407,800
Хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хувь	81,9%

Бизнесийн 3-р бүлгийн хувьд бие даан хөрөнгө оруулалт хийвэл хөрөнгө оруулалтаа 1,5 жилийн хугацаанд бүрэн төлөх боломжтой нь харагдаж байна. Эн бүлгийн хөрөнгө оруулалтын зардлыг төслөөс бүрэн хариуцаж байгаа болохоор 81,9%-ийн ашигтай ажиллах боломжтой байна

Бизнесийн 4-р бүлгийн санхүүгийн төлөвлөгөө

Борлуулалтын орлого

Бүрээгдэхүүн	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ	Тоо хэмжээ	Бүгд
Цагаан идээ	кг	3000	500	1,500,000
Сүү	л	1000	2000	2,000,000
Морь хөлслүүлэх	Морь/хоног	20000	150	3,000,000
Дүн				6,500,000

Бизнесийн 4-р чиглэлийн хувьд хашаа хороо, хадлан тэжээл гээд тодорхой хэмжээний байнгын зардлууд гарах боловч уламжлалт үндсэн аж ахуй тул нарийвчлан төлөвлөн шаардлагагүй гэж үзлээ.

Шинээр эхлэх зөгий үржүүлэх ажлын санхүүгийн төлөвлөгөө

Гол зардлууд

Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд
Тоног төхөөрөмж худалдан авах	Ком	2	1000000	2000000
Зөгийн бүл авах	ш	2	1500000	300000
Дүн				500000

Борлуулалтын орлого

Бүрээгдэхүүн	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ	Тоо хэмжээ	Бүгд
Зөгийн бал	кг	40000	150	6000000
Бусад бүтээгдэхүүн	Кг	20000	100	2000000
Дүн				8000000

АШГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Бизнес бүлгүүд	2020	2021	2022
1-р бүлэг	10425600	1500000	20000000
2-р бүлэг	1057500	2000000	3000000
3-р бүлэг	19800000	21000000	2300000
4-р бүлэг	6500000	6500000	6500000
Шинээр эхлэх		7500000	8000000
	37,783,100	38500000	39800000

2020 оны тооцоог суурь үзүүлэлт болгож ашгийн хэмжээг 3 жилийн хугацаагаар төлөвлөлөө.

1-р бүлгийн хувьд менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ойн цэвэрлэгээ хийх талбайн, гарах модлогийн хэмжээг үндэслэн жил тутам 50%-ийн өсөлттэй байхаар төлөвлөлөө.

2-р бүлгийн хувьд самар жимс мөөг ашиглах талбайг арчлалт хамгаалалт хийх замаар нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэх, талбайн хэмжээг менежментийн төлөвлөгөөнд заагдсан газруудад тэлж ашиглах замаар жил тутам 50%-иар нэмэгдүүлэхээр тооцлоо.

3-р бүлгийн хувьд жил тутам 20% өсөлттэй байхаар тооцов.

4-р бүлгийн хувьд Уламжлалт мал аж ахуйгаас олох орлого ашгийг цаашид өсгөхгүй тогтвортой байлгахаар төлөвлөж байна. Нөхөрлөлийн орлого ашигт мал аж ахуйгаа олох хувийг багасгаж байгалиа хамгаалах түүний нөөц баялгийг тогтвортой ашиглах, байгальд халгүй жижиг дунд үйлдвэрлэлийг нэвтрүүлэх шаардлагатай гэж үзэж зөгийн аж ахуй эрхлэх бизнесийн төлөвлөлтийг нэмж оруулав.

5.Өрсөлдөгчдийн судалгаа

Өрсөлдөгчдийн судалгаа нь ижил төрлийн бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлдэг субъектуудын бүтээгдэхүүн, зах зээлийн багтаамжийг судалж өөрсдийн бүтээгдэхүүний үнэ, хүргэх үйлчилгээ, ялгарах онцлог зэргийг сайтар бодож хэрхэн зах зээлд нийлүүлэх аргыг боловсруулна гэсэн үг.

Бизнесийн 1-р бүлэг

Өрсөлдөгчид	Бүтээгдэхүүн	Бүтээгдэхүүний чанар	Үнэ	Зах зээл

Бизнесийн 2-р бүлэг

Өрсөлдөгчид	Бүтээгдэхүүн	Бүтээгдэхүүний чанар	Үнэ	Зах зээл

Бизнесийн -р бүлэг

Өрсөлдөгчид	Бүтээгдэхүүн	Бүтээгдэхүүний чанар	Үнэ	Зах зээл

6. Эрсдэлийн төлөвлөгөө

Ойн нөхөрлөл нь байгаль, цаг уурын бэрхшээл, мөн зах зээлийн нөхцөл, санхүүгийн хүчин зүйлс зэрэг гэнэтийн ямар нэгэн хүндрэл, дэд бүтцийн болон эрхзүйн орчинд гарсан өөрчлөлт зэргээс шалтгаалан бизнесийн зорилгыг хэрэгжүүлэх үйл явц удаашрах, зарим үйл ажиллагаанууд биелэгдэхгүй байж болно. Тохиолдох эрсдэлүүдийг урьдчилан тооцохдоо илрэх хэлбэр, учирч болох үр дүн, тухайн эрсдэлээс хамгаалах, зайлсхийх шийдэлийг төлөвлөх хэрэгтэй.

Бизнесийн 1-р бүлэг

Зах зээл	Байгаль орчин	Нийгэм эрх зүй санхүү	Техник технологи
Эрсдэл: - Өрсөлдөгчид түлээгээ илүү хямд үнээр зарах - Хууль бусаар бэлтгэсэн илүү чанартай түлээ	Эрсдэл: -Ойн түймэр -Хууль бус мод бэлтгэл -Зах зээлд ойр нөөц шавхагдах -Зам харилцаа муу	Эрсдэл: -ойн түймрээс сэргийлэхэд нөхөрлөлийн дундын сан хүрэлцэхгүй -Мод бэлтгэх зөвшөөрөл олдохгүй	Эрсдэл: -Багаж хэрэгсэл элэгдэж эвдэрч хуучрах -Тээврийн хэрэгсэл дутмаг -Тээврийн машины түрээс нэмэгдэх
Шийдэл: -Сумын ЗДТГ-аар дамжуулах хуулийн дагуу бэлтгэсэн түлээг сурталчлах - Төсвийн байгууллагад зөвшөөрлийн дагуу бэлтгэсэн түлээ нийлүүлэх	Шийдэл: -Ойн түймрээс сэргийлэх арга хэмжээг сайжруулах – Сумын ЗД болон ойн анги, хамгаалалтын захиргаатай хамтарч хулгайн модтой тэмцэх	Шийдэл: -Мөнгөн хуримтлалаа нэмэгдүүлэхийн тулд түлээний үнээ нэмэх талаар ойн анги Засаг даргаас дэмжлэг авах -Мод бэлтгэх зөвшөөрлөө авах арга замыг олох	Шийдэл: -Банкнаас зээл авах төсөл боловсруулах Өөрсдөө тээврийн машинтай болох

Бизнесийн 2-р бүлэг

Зах зээл	Байгаль орчин	Нийгэм эрх зүй санхүү	Техник технологи
Эрсдэл: -	Эрсдэл:	Эрсдэл:	Эрсдэл:
Шийдэл: -	Шийдэл: -	Шийдэл:	Шийдэл: -

Бизнесийн 3-р бүлэг

Зах зээл	Байгаль орчин	Нийгэм эрх зүй санхүү	Техник технологи
Эрсдэл: -	Эрсдэл:	Эрсдэл:	Эрсдэл:
Шийдэл: -	Шийдэл: -	Шийдэл:	Шийдэл: -

7. Хяналт үнэлгээ

Хяналт, үнэлгээ буюу мониторинг нь төлөвлөсөн ажлуудаа тогтмол хянаж, бодит байдал дээр төлөвлөгөөнөөс зөрсөн зүйл гарвал засч сайжруулахад чухал ач холбогдолтой. Тухайлбал, санхүүгийн тооцоо, төлөвлөсөн үйл ажиллагаанууд, бүтээгдэхүүний чанар зэргийг ажиглаж болно. Мониторинг явуулах тогтсон нэг арга хэрэгсэл гэж байхгүй ч зах зээл эдийн засаг, байгаль орчин түүхий эд, нийгэм эрхзүй, техник технологи гэсэг 4 хүрээнд үзэж чухам аль хүчин зүйлээс хамаарч байгааг тогтоож арга хэмжээ авах хэрэгтэй.